


UCS 1705A:2022

ХОГ ХАЯГДЛЫН УДИРДАМЖ




Хог хаягдлын устгалын стандарт,
устгалын удирдамж

ХОГ ХАЯГДЛЫН УДИРДАМЖ

Хог хаягдлын устгалын стандарт,
устгалын удирдамж

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 25-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	5
4. Энгийн хог хаягдлыг устгахад тавигдах ерөнхий шаардлага	6
5. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	9
6. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг.....	12
7. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хориглох үйл ажиллагаа.....	14
8. Хог хаягдлыг хими, биологи, физикийн аргаар боловсруулж устгах	15
9. Зориулалтын байгууламжид хог хаягдлыг шатааж устгах.....	19
10. Эрүүл мэндийн байгууллагаас үүсэх тусгай хог хаягдлыг устгах	20
11. Хог хаягдлын төвлөрсөн цэг, байгууламжийг хаах.....	22
Ашигласан материалуудын жагсаалт.....	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хог хаягдлыг устгах аргууд.....	6
Зураг 2. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүртгэлийн байр	8
Зураг 3. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршил тогтоох.....	9
Зураг 4. Хог хаягдлын төвлөрсөн цэг байрлуулахыг хориглосон байршил.....	10
Зураг 5. Энгийн хог хаягдлыг устгах байгууламжийн ерөнхий шаардлага.....	11
Зураг 6. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн зэрэглэл, ангилал.....	12
Зураг 7. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа	13
Зураг 8. Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа.....	13
Зураг 9. Үйл ажиллагааны төлөвлөгөө	14
Зураг 10. Байгаль орчныг хамгаалах менежмент, мониторинг хийх төлөвлөлт	14
Зураг 11. Хориглох үйл ажиллагаа.....	15
Зураг 12. Хог хаягдлыг ангилах үйлдвэрлэлийн зураглал.....	16
Зураг 13. Хар тугалгат-хүхрийн хүчлийн батарейг дахин боловсруулж болохыг заасан .. тэмдэг.....	17
Зураг 14. Асфальт бетон хучилт хуулах машин механизм.....	17
Зураг 15. Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн дахин боловсруулж ашиглах боломжтой эд анги.....	18
Зураг 16. Хаягдал цемент бетон дахин боловсруулах үйлдвэрлэлийн зураглал.....	18
Зураг 17. Аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагаа	20
Зураг 18. Эмнэлгийн аюултай, тусгай хог хаягдал устгах дараалал	21



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Хог хаягдлын менежментэд хамаарах
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Хог хаягдлын менежмент бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1703A:2022 “Аюултай хог хаягдлын менежмент” хотын стандарт

1.2. UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт

1.3. UCS 1706A:2022 “Барилгын хог хаягдлын менежмент” хотын стандарт

1.4. UCS1704A:2022 “Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны менежмент” хотын стандарт

1.5. UCS1705A:2022 “Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.


3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж. БАТБАЯСГАЛАН

1110100325



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 25
дугаар тогтоолын тавдугаар хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

USC 1705A:2022 “ХОГ ХАЯГДЛЫН УСТГАЛЫН СТАНДАРТ, УСТГАЛЫН УДИРДАМЖ” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг хог хаягдлын устгалын байгууламжийг төлөвлөх, зураг төсөл боловсруулах барилгын ажил гүйцэтгэх, ашиглах хог хаягдлыг устгахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Хог хаягдлын тухай хууль;
- Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага (Байгаль орчин, аялал, жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал);
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох, үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавих шаардлага болон зөвшөөрөл олгох журам (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/18 дугаар тушаал);
- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам (Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоол);
- БНБД 81-95-12 /2020/ Барилгын төсөв зохиох дүрэм;
- БНБД 21-01-02. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм дүрэм;
- БНБД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл;
- БНБД 22-01-01. Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм;
- MNS 6342:2012 Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь аг12аар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS BS 5906 Барилга доторх хог хаягдлын менежмент - Ашиглалтын дүрэм;
- MNS ISO 11632 Байгаль орчин. Суурин эх үүсвэрээс ялгарах хаягдал. Хүхэрлэг хийн масс агууламжийг тодорхойлох. Ионы хроматографын арга;

- MNS 17-2-0-07 : 1979 Байгаль орчныг хамгаалах. Агаарыг бохирдуулах хаягдал. Ангилал;
- MNS 6783 : 2019 Ашиглалтаас гарсан хар тугалгат- хүхрийн хүчлийн батарейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага
- MNS 6830:2020 Дахин боловсруулалтаас гарсан бетонон дайрга. Техникийн шаардлага;
- MNS 6567:2015 Автозамын байгууламжийн материал. Автозамын асфальт бетон хучилтыг дахин боловсруулах. Техникийн шаардлага;
- MNS 5566:2005. Аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага;
- MNS ISO 3833:2010. Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт
- MNS 6593:2016. Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 4978:2000. Аюултай ачаа. Ангилал.Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4596:2014. Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
- MNS 4643: 1998. Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө;
- MNS 5525 : 2005 Эрүүл мэндийг хамгаалах технологи - Эмнэлгийн зориулалттай нэг удаагийн аюулгүйн хайрцаг. Техникийн шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хог хаягдал – гэж өмчлөгч этгээдийн хэрэглэхгүй болсон эд юмс, материал;

Энгийн хог хаягдал – гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдал;

Ахуйн хог хаягдал – гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдал;

Хог хаягдлын үйлчилгээний байгууллага – гэж айл, аж ахуй нэгж байгууллагын хогийг цуглуулж тээвэрлэх, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцдаг байгууллага;

Хог хаягдлын үйлчилгээний хураамж – гэж хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булшлахад шаардагдах зардлын хувь хэмжээг харгалзан тогтоосон татвар;

Хог хаягдлын төвлөрсөн цэг – гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газар;

Хог хаягдлыг устгал – гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфиллд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалах үйл ажиллагаа;

Хог хаягдлыг шатаах – гэж хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатааж, задлах;

Хог хаягдал шатаах зориулалтын байгууламж – гэж хог хаягдлыг өндөр хэмд, хяналттай шатаах төхөөрөмж бүхий байгууламж;

Хог хаягдлыг булшлах – гэж хог хаягдлыг газарт булж хадгалах үйл ажиллагаа;

Ландфилл – гэж хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламж;

Хог хаягдлын хэмжээ – гэж тодорхой хугацаанд нэг иргэн, айл өрх, аж ахуй нэгж, байгууллагаас үүсэж буй хог хаягдлын хэмжээ;

Байгаль орчинд ээлтэй технологи – гэж уламжлалт технологитой харьцуулахад илүү сайжруулсан технологи бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө маш бага, эсхүл бүр сөрөг нөлөөгүй технологи;

Бүрэн хаах – гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн

үйл ажиллагааг зогсоож, зохих шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүйгээр хаах арга хэмжээ;

Хэсэгчлэн хаах – гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн үйл ажиллагааны нэг хэсгийг зохих шаардлагын дагуу хааж, зарим хэсэг нь уг ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах;

Шүүрэл – гэж аюултай хог хаягдлаас ялгарсан шингэн;

Биологийн боловсруулалт – гэж бичил биетээр бохирдуулагчийг устгах болон хоргүйжүүлэх;

Хими-физикийн боловсруулалт – гэж химийн болон физикийн боловсруулалтыг хослуулан хэрэглэх;

Химийн боловсруулалт – гэж химийн бодис ашиглаж хоргүйжүүлэх;

Физикийн боловсруулалт – гэж шүүх, тунадасжуулах, шингээх, нэрэх зэрэг аргаар бохирдуулагчийг цэвэрлэх;

Хог хаягдал дахин боловсруулах - гэж хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

Хог хаягдлыг ил шатаах - гэж хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус байгууламжид шатаах;

Чөлөөт шингэн – гэж хэвийн даралт болон температурын үед хаягдлын хатуу хэсгээс салгах боломжтой шингэн.

4. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Энгийн хог хаягдлыг устгах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.20-д заасныг ойлгох ба дараах хууль тогтоомжийг баримтална.

а) Хог хаягдлын тухай хуулийн 16, 17 дугаар зүйл;

б) Байгаль орчин, аялал, жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага”.

4.2. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор энгийн хог хаягдлыг устгахад дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал, 2.7.2). Үүнд:

а) хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий этгээд зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах;

б) химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах;

в) биологийн аргаар байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр боловсруулж устгах;

г) зориулалтын байгууламжид байгальд ээлтэй технологиор хог хаягдлыг шатаах;


д) хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд хоргүй болгож устгах.



Зураг 1. Хог хаягдлыг устгах аргууд (Жишээ зураг)

- 4.3. Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа хийгдсэний дараа үлдсэн хог хаягдлыг дээрх аргын аль тохирохыг ашиглан хог хаягдлыг устгана.
- 4.4. Энгийн хог хаягдал устгах байгууламжийг эрхлэгч нь дараах шаардлагын дагуу үйл ажиллагааг явуулна (Хог хаягдлын тухай хууль, 16 зүйл). Үүнд:
- а) хог хаягдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, дугаар авах;
 - б) үйл ажиллагаанд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулсан байх;
 - в) аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг орон нутгийн онцгой байдлын газраар батлуулах;
 - г) хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрэм боловсруулах
 - д) ажилтан, албан хаагчид нь тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;
 - е) устгасан хог хаягдлын бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлэх.
- 4.6. Иргэдийг хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайд нэвтрүүлэх, хог түүхийг хориглоно.
- 4.7. Биологийн болон хими, физикийн аргаар хог хаягдлыг устгахдаа ашиглах бодис, технологийн талаарх мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авсны дараа гүйцэтгэнэ.
- 4.8. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдал тээвэрлэж ирсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн хог хаягдлыг ландфиллд дарж булах зардлыг хог хаягдлын тухай хуулийн 9.1.4 дэх заалтад заасан энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифаар тооцож авна.
- 4.9. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүртгэлийн байр нь дараах тоног төхөөрөмжтэй байна. Үүнд:
- 4.9.1. авто машины дугаар мэдэрч бүхий хяналтын камер;
 - 4.9.2. авто машиныг жинг харуулсан гадна мэдээллийн дэлгэц;
 - 4.9.3. авто машины хог хаягдлын бүтцийг хянах камер;
 - 4.9.4. бүртгэлийн программ хангамж бүхий иж бүрэн компьютер, хэвлэх машин;
 - 4.9.5. хог хаягдлын төвлөрсөн цэг дээр ирж буй хог тээврийн авто машиныг бүртгэх мэдрэгч;
 - 4.9.6. дотор болон гадна хяналтын камер;
 - 4.9.7. бүртгэлийн программ хангамжтай холбоотой дижитал авто пүү;
 - 4.9.8. авто машиныг дугуйг ариутгах, цэвэрлэх төхөөрөмж;
 - 4.9.9. гадна гэрэлтүүлэг.

- 4.10. Хог хаягдал булшлах, устгах байгууламж уруу орох замыг хөрсөөр хучиж, нягтруулан хог тээврийн авто машин саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.11. Хог хаягдал тээвэрлэн ирж байгаа авто машиныг ачаатай үед хог хаягдлын төвлөрсөн цэгт орох пүү дээр жигнэж, бүртгэн, хэмжилт хийн, ачиж, тээвэрлэсэн хог хаягдлын эх үүсвэр, хог хаягдлын төрлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд хяналтын ажилтан ачиж, тээвэрлэсэн хог хаягдлыг шалгаж, нягтлан биологийн, химийн болон аюултай, шатах, дэлбэрэх эрсдэлтэй хог хаягдал илэрвэл хог хаягдлын төвлөрсөн цэгт нэвтрүүлэхгүй байна.
- 4.12. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдал тээвэрлэж ирсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн хог хаягдлыг ландфиллд дарж булах зардлыг Хог хаягдлын тухай хуулийн 9.1.4 дэх заалтад заасан энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифаар тооцож авна.
- 4.13. Хог хаягдал асгаж, буулгасны дараа хог хаягдлын төвлөрсөн цэгээс авто машин гарахад ачаагүй үеийн авто машины жинг хэмжиж, пүүлэх бөгөөд ачаатай үеийн жингийн зөрүүгээр хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэгдэн ирсэн хог хаягдлын хэмжээг тооцон бүртгэж, баталгаажуулна.
- 4.14. Тогтоосон цэгээс бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.




Зураг 2. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүртгэлийн байр (Жишээ зураг)

- 4.15. Хаагдсан ландфиллын газарт барилга барих, суурьшлын бүс байгуулахыг хориглоно.
- 4.16. Байгальд 5-10 жилд хоргүйгээр уусаж алга болох хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөгдсөн ландфилл талбайд зориулалтын тоног төхөөрөмжөөр булшилна.
- 4.17. Байгальд 10-аас дээш жилийн дараа уусах, байгальд хортой нөхцөл үүсгэх хог хаягдлыг булшлахаас бусад аргаар устгана.


5. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГ БАЙГУУЛАХ

- 5.1. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулахад үйл ажиллагааг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар” -г тус тус баримтална.
- 5.2. Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн байршлыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтооно.
- 5.3. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг тогтоохдоо тухайн газар нутгийн физик газарзүй, нийгэм, эдийн засаг, хүн амын тоо, үүсэх хог хаягдлын хэмжээ, газрын гадарга, инженер геологи, гидрогеологийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.



Зураг 3. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршил тогтоох (Жишээ зураг)

- 5.4. Энгийн хог хаягдлын устгалын байгууламжийг дараах байршилд барихыг хориглоно Үүнд: (Зураг 4).




Зураг 4. Хог хаягдлын төвлөрсөн цэг байрлуулахыг хориглосон байршил (Жишээ зураг)

5.5. Энгийн хог хаягдлыг устгах байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- 5.5.1. байгууламжид зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, мал, амьтан орохоос хамгаалсан хашаа;
- 5.5.2. харуул хамгаалалт, дохиоллын систем;
- 5.5.3. устгах хог хаягдлыг хэмжих хэрэгсэл бүхий бүртгэлийн байр;
- 5.5.4. үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хяналтын систем;
- 5.5.5. хяналтын камер;
- 5.5.6. хог хаягдлын бүтэц найрлагыг тогтоох тоног төхөөрөмж бүхий лаборатори, дээж авах багаж хэрэгсэл;
- 5.5.7. галын аюулгүй байдлын дохиолол, хамгааллын систем;
- 5.5.8. үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол гарсан үед мэдрэх хяналтын систем;
- 5.5.9. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмж;
- 5.5.10. үйл ажиллагаанаас үүсэх агаар, хөрс, усанд ялгарах ялгарлыг хянах систем;
- 5.5.11. төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдсон эсхүл хэсэгчилсэн инженерийн байгууламж;
- 5.5.12. хур борооны ус зайлуулах сувгийн систем;
- 5.5.13. нэвтрэх зам, төвлөрсөн цэгийн доторх гол ба туслах зам;
- 5.5.14. тэмдэг, тэмдэглэгээ;
- 5.5.15. хог хаягдлын хучилтын хөрс нөөцлөх талбай;
- 5.5.16. дулаан гарааш;

- 5.5.17. машин угаалга болон дугуй угаах цэг;
- 5.5.18. тусгаарлах зурвас, хамгаалалтын бүс;
- 5.5.19. хий зайлуулах;
- 5.5.20. бохир шингэн цуглуулах шүүлтүүр хоолой;
- 5.5.21. бохир шингэн ууршуулах;
- 5.5.22. хяналтын цооног найруулах;
- 5.5.23. шүүрэл нэвчихээс хамгаалсан доторлогоо.



Зураг 5. Энгийн хог хаягдлыг устгах байгууламжийн ерөнхий шаардлага (Жишээ зураг)

- 5.6. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг ландфиллын бүтэц, булшлах технологиос хамааруулж гурван зэрэглэлээр ангилах бөгөөд нэг, хоёр, гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэг нэмэлт шаардлагыг хангасан байна (энэ стандартын Зураг 6-д заасан нэмэлт шаардлагыг хангасан байна).
- 5.7. Төвлөрсөн цэгийг нэг болон хоёрдугаар зэрэглэлд хамааруулсан байдлаар төлөвлөх бөгөөд хамгаалалтын бүстэй байна.
- 5.8. Алслагдсан дүүргийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг 3 дугаар зэрэглэлд хамааруулан шаардлагуудыг хангасан байдлаар төлөвлөнө.



Зураг 6. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн зэрэглэл, ангилал (Жишээ зураг)

6. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГ


- 6.1. Төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.
- 6.2. Нэг болон хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгт дараах үйл ажиллагааг явуулна.

- 6.2.1. Хог хаягдлыг шалгаж, хэмжиж, бүртгэж хүлээж авах;
- 6.2.2. Хог хаягдлыг тархахаас сэргийлж хөрсөөр дарж нягтруулах;
- 6.2.3. Ландфиллын бүрэн бүтэн байдал болон шүүрлийн систем, хий зайлуулах систем, машин техникийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- 6.2.4. Хөрс, агаар, усны хяналт- шинжилгээний төлөвлөгөөтэй байх;
- 6.2.5. Булшилсан хог хаягдлын хэмжээ бүтцийн талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх.



Зураг 7. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа (Жишээ зураг)

- 6.3. Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгт дараах үйл ажиллагааг явуулна
 - 6.3.1. Хог хаягдлыг шалгаж, бүртгэж хүлээж авах;
 - 6.3.2. Хог хаягдлыг тархахаас сэргийлж бөөгнөрүүлэн дарж нягтруулах;
 - 6.3.3. Машин техникийн хэвийн үйл ажиллагааг хангах.



Зураг 8. Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа (Жишээ зураг)

6.4. Төвлөрсөн цэгийн зэрэглэлд тавигдах шаардлагад нийцүүлэн техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчин, дотоод зохион байгуулалт, менежментийн бодлогыг тусган үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллах ба төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана.



Зураг 9. Үйл ажиллагааны төлөвлөгөө (Жишээ зураг)

6.5. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, хяналт мониторингийн ажлыг жил бүр төлөвлөн ажиллана (Зураг 10).

6.6. Энгийн хог хаягдлыг устгах, булшлах үйл ажиллагааны өдөр тутмын хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох ба захиалагч хяналтын төрийн бус байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж ажиллуулна



Зураг 10. Байгаль орчныг хамгаалах менежмент, мониторинг хийх төлөвлөлт (Жишээ зураг)

7. ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГТ ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгт дараах хог хаягдал булшлахыг хориглоно.

- 7.1.1. Аюултай хог хаягдал;
- 7.1.2. Халдвартай хог хаягдал;
- 7.1.3. Шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал.

7.2. Хог хаягдал шатаахыг хориглоно.

7.3. Зөвшөөрөлгүй иргэн болон мал, амьтныг хог хаягдлыг хүлээж авах, булшлах талбайд оруулахыг хориглоно.

7.4. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үүр болон хог хаягдал хүлээн авч буй талбайд ил гал гаргах, тамхи татах болон шатах, тослох материал агуулахгүй байна (Зураг 11).



Зураг 11. Хориглох үйл ажиллагаа (Жишээ зураг)

8. ХОГ ХАЯГДЛЫГ ХИМИ, БИОЛОГИ, ФИЗИКИЙН АРГААР БОЛОВСРУУЛЖ УСТГАХ

8.1. Хог хаягдлыг зориулалтын дагуу устгахдаа байгаль орчинд ээлтэй технологиор, олон улсын байгууллага хүлээн зөвшөөрсөн арга, техник хэрэгслээр устгана.


8.2. Энгийн хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2 дахь заалтад заасан зөвшөөрөл авсан, 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, журмын 1.6 дахь заалтад заасны дагуу нийслэлийн хог хаягдлын менежментийн бүртгэл, хяналтын нэгдсэн цахим санд бүртгүүлсэн хуулийн этгээд гүйцэтгэнэ.

8.3. Энгийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

8.4. Ландфиллд булшлах аргыг аль болох ашиглахгүй, бусад аргыг ашиглахыг нэн тэргүүнд тавина.

8.5. Сэргээн ашигласан, дахин боловсруулсан, устгасан, булшилсан хог хаягдлын бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлнэ.

8.6. Дахин боловсруулах, сэргээн ашиглах хог хаягдлын үйлдвэрлэлийн процесс, технологийг харуулсан зураглал, схемийг гаргаж олон нийтэд нээлттэй байршуулна.



Зураг 12. Хог хаягдлыг ангилах үйлдвэрлэлийн зураглал (Жишээ зураг)

- 8.7. Дахин боловсруулах, сэргээн ашиглах хог хаягдал хүлээн авах талбай хатуу хучилттай, дээвэртэй, хог хаягдал салхиар тархах, хийсэхээс сэргийлсэн хашаатай байх ба хог хаягдлын бүтэц, найрлагыг тогтоох, хэмжих, ачиж буулгах, шахаж нягтруулах техник, тоног төхөөрөмжтэй байна.
- 8.8. Эрүүл ахуйн шаардлага хангасан, лабораторийн шинжилгээгээр хүлээн зөвшөөрөгдсөн хог хаягдлаар дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.
- 8.9. Төвлөрсөн хот, суурин газарт энгийн хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар нутаг, суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно.
- 8.10. Дахин боловсруулах үйлдвэрээс гарсан шинэ бүтээгдэхүүн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчинд аюулгүй хүний хэрэгцээ 9.12. шаардлагыг хангасан байна.
- 8.11. Ашиглалтаас гарсан батареиг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр үйлдвэрлэлийн аргаар дахин боловсруулан хуванцар, хар тугалга, хүхрийн хүчил зэрэг материал тус бүрээр ангилан ялгаж, түүхий эд үйлдвэрлэнэ.



Зураг 13. Хар тугалгат-хүхрийн хүчлийн батарейг дахин боловсруулж болохыг заасан тэмдэг (Жишээ зураг)

- 8.12. Асфальт бетон хучилтыг дахин боловсруулахад MNS 6567:2015 (Автозамын байгууламжийн материал. Автозамын асфальт бетон хучилтыг дахин боловсруулах. Техникийн шаардлага) стандартын дагуу хийгдэх бөгөөд дахин боловсруулахдаа аль аргыг ашигласнаас хамааран авто замын засварын ажилд нөхцөлд байдалдаа тохируулан хэрэглэнэ.
- 8.13. Асфальт бетон хучилтыг дахин боловсруулах дараах 4 төрлийн технологийг ашиглана. Үүнд:
- 8.13.1. асфальт бетоныг үйлдвэрт халуун аргаар дахин боловсруулж хэрэглэх;
 - 8.13.2. газар дээр нь халуун аргаар дахин боловсруулж шинэчлэх;
 - 8.13.3. асфальт бетоныг үйлдвэрт хүйтэн аргаар дахин боловсруулж хэрэглэх;
 - 8.13.4. хүйтэн аргаар газар дээр нь дахин боловсруулж шинэчлэх.




Зураг 14. Асфальт бетон хучилт хуулах машин механизм (Жишээ зураг)

- 8.14. Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгсэл түүний түүхий эдийг устгах, дахин боловсруулах, хяналтын тогтолцоог бий болгох, байгаль орчинд халгүй аргаар дахин ашиглах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг MNS 6594:2016 (Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрлэл. Ерөнхий шаардлага) стандартыг баримтална.
- 8.15. Ашиглалтаас хасагдсан авто тээврийн хэрэгслийн эд ангийг дахин боловсруулж, ашиглах боломжтой эд ангийг ангилан ялгаж, холбогдох стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.



Зураг 15. Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн дахин боловсруулж ашиглах боломжтой эд анги (Жишээ зураг)


- 8.16. Цементэн бетон барилга, байгууламжийн нураалтаас гарсан том хэсгүүд болон бетон үйлдвэрлэлийн гологдол бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар буталж, ангилан дахин боловсруулж бетонон дайрга үйлдвэрлэж болох бөгөөд MNS 6830:2020 (Дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дайрга. Техникийн шаардлага) стандартыг баримтална.



Зураг 16. Хаягдал цемент бетон дахин боловсруулах үйлдвэрлэлийн зураглал (Жишээ зураг)

9. ЗОРИУЛАЛТЫН БАЙГУУЛАМЖИД ХОГ ХАЯГДЛЫГ ШАТААЖ УСТГАХ

- 9.1. Аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 5 дугаар бүлэг, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 116 дугаар тогтоол (Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам) болон холбогдох дүрэм, журмыг баримтална.
- 9.2. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламж дараах шаардлагыг хангасан байна (Хог хаягдлын тухай хууль, 25.3). Үүнд:
 - 9.2.1. нэг хувийн чийгийн хангамшилтай жилийн үерийн урсцын хэмжээнд тооцсон үерийн хамгаалалтын барилга байгууламжтай;
 - 9.2.2. нэг хувийн чийгийн хангамшилтай жилийн үерийн урсцын хэмжээнд тооцсон эзлэхүүн бүхий гадаргын ус цуглуулах сантай;
 - 9.2.3. хүчтэй газар хөдлөлийн нөлөөллийг тооцож байгууламжийг барьсан;
 - 9.2.4. хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах хэмжээгээр агаар, хөрс, усанд санамсаргүй болон санаатайгаар аюултай хог хаягдал алдах, тэсэрч дэлбэрэх, галын аюул үүсэх боломжийг хамгийн бага хэмжээнд байхаар төлөвлөж баригдсан;
 - 9.2.5. зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, мал амьтан орохоос хамгаалсан хашаа, харуул хамгаалалттай, байгууламжийн орох, гарах хаалга болон дотор, гадна талбай, зам, устгалын үйл ажиллагааг тасралтгүй хянах хяналтын системтэй;
 - 9.2.6. гадна болон дотор талбайд аюул, ослын үед ажиллах машин, техник, тоног төхөөрөмж ажиллах нөхцөлийг хангасан орц, гарц, замтай;
 - 9.2.7. аюулгүй ажиллагааны болон аюул, ослын үед ажиллах дохиоллын систем, хариу арга хэмжээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, материалаар тоноглогдсон.
- 9.3. Аюултай хог хаягдал шатааж устгах үйл ажиллагаанд дараах нэмэлт шаардлагыг хангасан байна (Хог хаягдлын тухай хууль, 35, 36 дугаар зүйл) Үүнд:
 - 9.3.1. аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагаа эрхлэгч нь туршилтын шатаалт хийж, үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлтийг тогтооно;
 - 9.3.2. туршилтын шатаалтыг 30 хоног явуулах ба энэ хугацаанд шаталт тогтворжиж, шаардлагатай түвшинд хүрээгүй тохиолдолд хугацааг 30 хоног хүртэл хугацаагаар сунгаж болно;
 - 9.3.3. аюултай хог хаягдал шатаах зуух нь зуухны үйл ажиллагаа доголдох үед хог хаягдал ачаалах үйлдлийг зогсоох автомат системтэй байна;
 - 9.3.4. аюултай хог хаягдал шатаах зуух нь шаталт болон ялгаралд хяналт тавих төхөөрөмжтэй байх ба уг төхөөрөмж нь аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын шаардлагыг хангасан байна;




Зураг 17. Аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагаа (Жишээ зураг)

- 9.3.5. зууханд өгөх хог хаягдлын ачаалалт болон зуухны бүтцэд өөрчлөлт гарах, зуухны үйл ажиллагааны үзүүлэлт зөвшөөрөгдсөн хязгаараас давсан тохиолдолд зуухны үйл ажиллагааг зогсооно;
- 9.3.6. шатаалтын зуух болон дагалдах тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд өдөрт нэгээс багагүй удаа хяналт тавина;
- 9.3.7. аюултай хог хаягдал шатааж устгах үйл ажиллагаанаас агаарт ялгарах хий дэх бохирдуулагч бодисын хэмжээ нь стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна;
- 9.3.8. аюултай хог хаягдал шатааж устгах байгууламжийн хий цэвэрлэх системээс үүссэн тоос, зуухны доод үнс зэрэг хатуу хаягдлыг зохих технологийн дагуу боловсруулж, аюултай хог хаягдлын ландфиллд булж устгана.
- 9.3.9. аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд “UCS 1701A” стандартыг баримтална.

10. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ҮҮСЭХ ТУСГАЙ ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ

- 10.1. Эрүүл мэндийн байгууллагаас гарсан тусгай хог хаягдлыг устгахад дараах аргуудын аль тохирохыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ. Үүнд:
 - 10.1.1. өндөр даралттай уураар халдваргүйжүүлэх;
 - 10.1.2. хуурай халуунаар халдваргүйжүүлэх;
 - 10.1.3. бичил долгионоор халдваргүйжүүлэх;
 - 10.1.4. химийн аргаар халдваргүйжүүлэх, саармагжуулах, хоргүйжүүлэх;
 - 10.1.5. булах, булшлах;
 - 10.1.6. шатаах арга.

10.2. Автоклавт хог хаягдлын материалын төрөл, хэмжээ зэргээс хамааран халдваргүйжүүлэх хугацаа, халууны хэм өөр өөр байна. Аюултай хог хаягдлыг автоклавт 121°C-ын хэмд 20 минут, 134°C-ын хэмд 10 минутын хугацаанд халдваргүйжүүлнэ. Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг өндөр даралтат уурын өнгөний хувиралтай туузан индикатораар хяналт тавина.



Зураг 18. Эмнэлгийн аюултай, тусгай хог хаягдал устгах дараалал (Жишээ зураг)

10.3. Эмчилгээ оношилгооны зориулалтаар хэрэглэгдсэн хурц ирмэгтэй нэг удаагийн багаж, хэрэгслийг цуглуулж устгахад аюулгүйн хайрцгийг ашиглах бөгөөд MNS 5525:2005 (Эрүүл мэндийн хамгаалах технологи. Эмнэлгийн зориулалттай нэг удаагийн аюулгүйн хайрцаг. Техникийн шаардлага) стандартыг баримтална.

10.4. Халдвартай хаягдлыг устгахдаа дараах удирдамжийг баримтална. Үүнд:

- 10.4.1. олон улсын хөл хориот болон БГХӨ, ДОХ, тэмбүү, сүрьеэ, сахуу балнад зэрэг халдварт өвчтэй хүний цус, био шингэн хаягдлыг тухайн байгууллагын тасаг, нэгжид урьдчилан химийн аргаар эсхүл өндөр даралттай уураар халдваргүйжүүлсний дараа бохир усны шугамд нийлүүлэх буюу шаардлага хангасан бохирын цооногт хаяна;
- 10.4.2. халдвартай шингэн ялгадсыг халдваргүйжүүлэхийн тулд гипохлорид кальци 1:5 хэмжээтэй хийж 1цаг, 3-5 хувийн хлорамин "Б" 2:1 хэмжээтэй хийж, 1-2 цаг байлгах бөгөөд өтгөн ялгадсыг 1 литрт 400 грамм хлорын шохой байхаар тооцож, 2 цаг байлгаж халдваргүйжүүлнэ;
- 10.4.3. нэг удаагийн хэрэглээний багаж хэрэгсэл, боолтын материалыг өндөр даралттай уураар халдваргүйжүүлж, зориулалтын багаж, хэрэгслээр буталж, жижиглэн ашиглах боломжгүй хэлбэрт оруулан ахуйн хогийн цэгт хаях, эсхүл зориулалтын зууханд шатааж устгана;
- 10.4.4. лабораториос ялгарсан халдварын зэрэглэл өндөртэй хаягдлыг өндөр даралттай уураар халдваргүйжүүлсний дараа төвлөрсөн бохир ус зайлуулах шугамд буюу шаардлага хангасан бохирын цооногт хаях ба эмгэг хаягдлыг шатаах буюу булаах аргаар устгана;
- 10.4.5. халдвартай болон халдварын сэжигтэй эмгэг хаягдлыг химийн аргаар халдваргүйжүүлж, ландфиллд булшлах аргаар устгана;
- 10.4.6. нэг удаагийн хэрэглээний зүү тариурыг хэрэглэсний дараа шууд аюулгүй хайрцагт цуглуулж, зориулалтын зууханд шатаах эсвэл өндөр даралттай уураар

халдваргүйжүүлж, зориулалтын багаж, хэрэгслээр буталж, жижиглэн ашиглах боломжгүй хэлбэрт оруулан эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллд булшилна.

10.5. Эм, био бэлдмэлийн хаягдлыг дараах аргаар устгана. Үүнд:

- 10.5.1. маш бага хэмжээний шингэн болон хагас шингэн хаягдлыг их хэмжээний усаар шингэрүүлж бохир усны шугамд хаяна;
- 10.5.2. хаягдлыг цемент, элс зэргээр чигжиж /хаягдал 65 хувь, шохой 15 хувь, цемент 15 хувь, ус 5 хувь тус тус байна/, бүрхүүлдсэний дараа булна;
- 10.5.3. эсэд хортой нөлөөтэй хаягдлыг ханган нийлүүлэгчид нь буцааж өгөх, эсвэл зориулалтын зууханд өндөр хэмд /1000-1200°C/ шатааж устгана;
- 10.5.4. химийн хаягдлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, зааврын дагуу устгана;
- 10.5.5. даралтат сав нь тэсрэх аюултай тул эмнэлэг үйлчилгээний хаягдалтай хольж шатааж болохгүй бөгөөд ханган нийлүүлэгчид буцааж өгөх эргүүлж ашиглах, бүрэн хоосолсны дараа ердийн хаягдалтай хаях аргаар устгана.

10.6. Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж нь төвлөрсөн буюу хэсгийн бохир ус зайлуулах шугамд холбогдсон бол хаягдлыг урьдчилан хоргүйжүүлж, саармагжуулж, халдваргүйжүүлсний дараа шугамд нийлүүлэх ба хэрэв бохир ус зайлуулах шугамд холбогдоогүй бол бие засах газар, бохирын цооногт хаях бөгөөд бохирын цооног нь хөрс, газрын доорх усыг бохирдуулахгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх бөгөөд тэдгээрийг тогтмол хугацаанд халдваргүйжүүлэх шаардлагатай.

10.7. Эмнэлгийн аюултай, тусгай хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэхдээ өндөр даралтад уур үүсгэгч автоклаваар халдваргүйжүүлнэ.

10.8. Автоклаваар халдваргүйжүүлэхдээ хог хаягдлын уут, савны бүрэн бүтэн байдлыг сайтар шалгах бөгөөд автоклавын дотор хананд ямар нэгэн эд зүйлийг тулган тавихгүйгээр уут савтай хог хаягдлыг автоклав дотор сийрэг байрлуулах бөгөөд овор ихтэй, хүнд жинтэй хог хаягдлыг доод хэсэгт байрлуулна.

11. ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГ, БАЙГУУЛАМЖИЙГ ХААХ

11.1. Хог хаягдлын төвлөрсөн цэг, байгууламжийг хэсэгчлэн болон бүрэн хааж болох бөгөөд Хог хаягдлын тухай хуулийн 19 дүгээр зүйл, 31 дүгээр зүйл, Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 тоот тушаал) болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, заавар, норм дүрмийг баримтална.

11.2. Төвлөрсөн цэгийн төлөвлөсөн ашиглалтын хугацаа дуусахаас 5 жилийн өмнө хаалтын төлөвлөгөө боловсруулна (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 тоот тушаал, 4.1)

11.3. Төвлөрсөн хогийн цэгийг дараах нөхцөл үүссэн тохиолдолд бүрэн хаах тухай шийдвэр гаргаж холбогдох эрх бүхий байгууллагад хангана. боловсруулна (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 тоот тушаал, 4.2). Үүнд:

- 11.3.1. зөвшөөрөгдсөн зай талбайд хог хаягдал булшилж, нөөц газар талбайгүй болсон, талбай бүрэн дүүрсэн;
- 11.3.2. байгаль орчны хяналт шинжилгээгээр хангалтгүй дүгнэлт удаа дараа авсан;
- 11.3.3. байгаль экологийн өөрчлөлт орж, хөрс нурсан, газар хөдөлсөн, үер ус орсон нь цаашид ландфиллээр ашиглах боломжгүй болсон;
- 11.3.4. хот, суурьшлын шинэ бүс болж хотын шинэ төлөвлөлтөд орсон;

- 11.3.5. Хүний эрүүл мэнд, амьтан, ургамал, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа болон үзүүлж болзошгүй нөхцөл үүссэн.
- 11.4. Төвлөрсөн хогийн цэгийг дараах нөхцөл үүссэн тохиолдолд хэсэгчлэн хаах тухай шийдвэр гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад хангана. боловсруулна.
- 11.4.1. Ландфилл талбайн зарим хэсэгт хог хаягдал булшилж, тохижилт бүрэн хийн, нийтийн эзэмшлийн талбай болгох шаардлага хангасан;
- 11.4.2. Талбайн хэсэг газарт экологийн өөрчлөлт орж, хөрс нурсан, газар хөдөлсөн, үер ус орсон нь ландфиллийг бүрэн хаахгүйгээр хэсэгчлэн хаах боломжтой бол;
- 11.4.3. Дээд газраас буюу орон нутгийн Засаг даргаас хэсэгчлэн хаах чиглэл өгсөн; (Тухайн Засаг даргын чиглэлд хэсэгчлэн хаах болсон шалтгаан, үндэслэл, эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээ, холбогдох дээд шатны байгууллагын шийдвэр зэргийг дэлгэрэнгүй тусгасан байна).
- 11.5. Ландфиллыг хаах болон хаасны дараах хяналт-шинжилгээ, арчилгаа үйлчилгээг ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл гэрээ байгуулсан байгууллага гүйцэтгэнэ.
- 11.6. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгууламжийг хэсэгчлэн болон бүрэн хаах хаалтын төлөвлөгөө, шаардагдах зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах бөгөөд сүүлчийн хаягдлыг хүлээн авснаас хойш 180 хоногийн дотор байгууламжийг бүрэн хаах хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусгана (Хог хаягдлын тухай хууль, 32 дүгээр зүйл).
- 11.7. Аюултай хог хаягдлын байгууламжийг хаасны дараах хяналт шинжилгээг 20 жилийн турш хийнэ (Хог хаягдлын тухай хууль, 32.2).
- 11.8. Ландфилл хаах этгээд ландфилл хааснаас хойш 5-10 жил тухайн газрын орчны тохижилтыг хариуцаж ажиллана (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 тоот тушаал, 4.5.1).
- 11.9. Хаасан ландфилл нь дараах шаардлагыг хангасан байна (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 тоот тушаал, 4.6).
- 11.9.1. Хучилтын хөрс эрүүл, зузааны хэмжээ 5-аас доошгүй метр байх;
- 11.9.2. Хөрс гулгахгүй, нурахгүй, шороо хийсэхгүй, бохир хөрс ил гарахгүй байх;
- 11.9.3. Урт хугацааны явцад хог хаягдал ил гарч ирэхгүй байх;
- 11.9.4. Булшилсан хог хаягдалд хими, физикийн өөрчлөлт орж, хөрс цөмрөх, нүх гарах, хөрс, гадаргуу өөрчлөгдөхгүй байх;
- 11.9.5. Хөрсийг бүрэн зүлэгжүүлж, шаардлагатай газар мод тарих, ландфиллийн онцлогоос хамаарч амралт зугаалгын газар болгож тохижуулах, гүйлтийн болон дугуйн зам тавих;
- 11.9.6. Үер, усны аюулаас бүрэн хамгаалж, хаалт хашлага, далан шуудуу татах;
- 11.9.7. Хог хаягдлаас үүсэх хийг аюулгүй байлгах нөхцөлийг бүрдүүлэх.
- 11.10. Төвлөрсөн цэгийн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байцаагч, байгаль орчны байцаагч, Хог хаягдлын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, байгаль хамгаалагчид хяналт тавина (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/445 тоот тушаал, 5.2).

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2017 оны 5 дугаар сарын 12)
- Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2008 оны 5 дугаар сар)
- Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2016 оны 2 дугаар сарын 05)
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014 оны 9 дүгээр 18-ны МУ-ын ЗГ-ын 298 дугаар тогтоол)
- МУ-ын ЗГ-ын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн үзэл баримтлал, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”
- Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага (Байгаль орчин, аялал, жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал)
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох, үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/18 дугаар тушаал)
- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам (Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоол)
- БОАЖЯ, “Environmental assessment report of Mongolia-2017-2018.” 2019.
- Environment Agency, “Waste Classification - Guidance on the classification and assessment of waste (Edition 1.1) Technical Guidance WM3
- European Commission, “Commission notice on technical guidance on the classification of waste,” *Off. J. Eur. Union*, vol. C 124, no. June 2015, p. 134, 2018.
- Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах журам
- БНБД 81-95-12 /2020/ Барилгын төсөв зохиох дүрэм
- БНБД 21-01-02. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм дүрэм
- БНБД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиололын хэрэгсэл
- БНБД 22-01-01. Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм
- MNS 6830:2020 Дахин боловсруулалтаас гарсан бетонон дайрга. Техникийн шаардлага
- MNS 6783:2019 Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батареиг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага
- MNS 6567:2015 Автозамын байгууламжийн материал. Автозамын асфальт бетон хучилтыг дахин боловсруулах. Техникийн шаардлага
- MNS 5566:2005. Аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
- MNS 5125:2005 Эрүүл мэндийн хамгаалах технологи. Эмнэлгийн зориулалттай нэг удаагийн аюулгүйн хайрцаг. Техникийн шаардлага

- MNS ISO 3833:2010. Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт
- MNS 6593:2016. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 4978:2000. Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 4596:2014. Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
- MNS 4643: 1998. Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар